



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 1/176

Чангис хот

Эд хөрөнгө актлах, худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, 29.1.2-ын "а" "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит 2 байгууллагын 10 816 000 төгрөгийн балансын үнэтэй, 3 219 746 төгрөг 28 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 7 596 253 төгрөг 72 мөнгөний үлдэх өртөгтэй актлах 2 нэр төрлийн эд хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчит 2 байгууллагын 70 881 600 төгрөгийн балансын үнэтэй, 22 327 000 төгрөг 12 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 48 554 599 төгрөг 88 мөнгөний үлдэх өртөгтэй эд хөрөнгийг эзэмшил газрын хамт худалдахаар хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Худалдах хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ц.Дэмбэрэлсайхан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч:

С.Энхцэцэг

Орон нутгийн өмчийн газрын
мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч

Л.Оюунтуяа

Орон нутгийн өмчийн газрын нягтлан
бодогч, бичиг хэрэг

4. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 11:00 цагт Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулсугай.

5. Эд хөрөнгийг актлах, худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА